

**МОНГОЛ УЛСЫН
"ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН
СТРАТЕГИ"
(2025-2030)-ИЙН
ТӨСӨЛД
ХҮРГҮҮЛЭХ САНАЛ**

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



Монгол Улсын “Залуучуудын хөгжлийн стратеги (2025-2030)-д” санал өгөх Монголын Эмнести Интернэшнлийн залуучуудын эхний хэлэлцүүлгээс гарсан саналыг 2025 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр нэгтгэн гаргав.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг 6-р хороо, АБ центр, 701 тоот
www.amnesty.mn

© Монголын Эмнести Интернэшнл

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн асуудлаар кампанит ажил өрнүүлдэг дэлхийн 150 гаруй орны 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн баримт бичгээр хамгаалагдсан эрхийг хүн бүрт эдлүүлэх нь бидний эрхэм зорилго. Бид хүний эрхийн зөрчлийг эцэс болгохын тулд судалгаа, кампанит ажил, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг. Эмнести Интернэшнл нь аливаа засгийн газар, улс төрийн үзэл, эдийн засгийн ашиг сонирхол болон шашнаас хараат бус болно. Бидний үйл ажиллагаа ихэвчлэн гишүүнчлэлийн хураамж, олон нийтийн хандиваар санхүүждэг.

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2025 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр Монголын Эмнести Интернэшнл (МЭИ)-ийн залуучууд Монгол Улсын 2025-2030 оны “Залуучуудын хөгжлийн стратеги”-д санал өгөх эхний хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн хүргүүлж байна.

Монгол Улсын “Залуучуудын хөгжлийн стратеги” (2025-2030) төсөл нь Монгол улсын урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнүүд болон “Тогтвортой хөгжлийн зорилго-2030, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээ”, “Ирээдүй хойч үеийн асуудлаарх тунхаглал” зэрэг олон улсын баримт бичгүүдийн үзэл санаанд уялдан, Монголын залуучуудын тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлсон, бодит байдалд нийцсэн, үндэслэл бүхий судалгаанд суурилан боловсруулагдах шаардлагатай байна.

Залуучуудын хөгжлийн алсын хараа нь хэт ерөнхий, зорилт, түүнд хүрэх арга зам тодорхой бус, шалгуур үзүүлэлт хэмжигдэхүйц биш, хяналт, үнэлгээний механизм тусгагдаагүй, стратегийн үндэслэл нь Монголын залуучуудад тулгамдаж буй асуудлыг нарийвчлан тодорхойлоогүй, стратегийн төсөлд дурдсан судалгаануудыг нэгтгэн дүн шинжилгээ, боловсруулалт хийгээгүй, зарим тоон судалгаанууд нь Ковид-19 цар тахлаас өмнөх буюу 4-5 жилийн өмнөх судалгаанаас эш татсан зэрэг нь стратегийн арга хэмжээг алдаатай төлөвлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Стратегийг хэрэгжүүлэх бүхий л үе шатад хүний эрхийн хэм хэмжээг хангах, залуучуудын нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, нийгмийн хөгжлөөс хүртэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван хуран чуулах эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрхтэй холбоотой цогц үйл ажиллагаа төлөвлөөгүй, олон талт хамтын ажиллагааг хэрхэн хангах нь тодорхойгүй байна.

Тиймээс МЭИ-ийн залуучууд зөвхөн стратегийн баримт бичгийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудыг нэгтгэсэн бөгөөд дараагийн хэлэлцүүлгээр стратегийн үзэл санаа, төлөвлөлтийг хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулах талаар тусгайлсан саналыг хүргүүлэх болно.

СТРАТЕГИЙН ТӨСЛИЙН АГУУЛГА, ШААРДЛАГЫН ХҮРЭЭНД:

1. Стратегийн төслийн үндсэн шаардлагуудыг хангах

Стратегийн төслийн хувьд “Стратегийн төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах” журамд¹ заасны дагуу хэлбэрийн болон агуулгын шаардлагыг анхаарч, мэргэжлийн түвшинд боловсруулах, ялангуяа дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Үүнд:

Мандатын шинжилгээ: Залуучуудын хөгжлийг дэмжин ажиллахад салбарын болон салбар дундын уялдааг хангах, оролцогч талуудад хамаарах чиг үүргүүдийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой байдаг. Стратегийн арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд олон талыг дурдсан ч талуудын холбогдох үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхой дурдаагүй байна.

Бодлогын нэгдмэл байдал, салбар хоорондын уялдаа, үүрэг хариуцлага, иргэний нийгмийн оролцоог хэрхэн хангах асуудал тодорхой бус байна. Ялангуяа “Бодлогын санал өгөх, хамтран хэрэгжүүлэх, стратегийн хяналт, үнэлгээ, хөндлөнгийн мониторинг хийх, шийдвэр гаргах процесс дахь оролцоо” зэрэг бүх түвшинд иргэний нийгмийн хяналт, оролцоог баталгаажуулах механизмыг стратегид тодорхой тусгах шаардлагатай.

Алсын хараа: Стратегийн алсын хараа нь өргөн хүрээтэй, хэт ерөнхий агуулгатай байна.

Жишээ нь: "Монгол залуучуудын хөгжлийг хурдасгаж, хүртээмжтэй, тогтвортой орчныг бүрдүүлэх" гэж томъёолсон боловч хөгжлийг хэрхэн хурдасгах, ямар байдлаар хүртээмжтэй, тогтвортой болгох талаар стратегийн төсөлд тодорхой заагаагүй. Залуучуудын стратегийн үнэт зүйл, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үнэлгээний шатад залуучуудын бодит оролцоо нэн чухал болохыг баталгаажуулах шаардлагатай байна. НҮБ-ын Залуучуудын стратеги 2030²-д залуучуудын оролцоог чухалчлан онцолсон байдаг бөгөөд залуучуудын санаачилгыг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай (SDG) уялдаж, залуучуудын манлайллыг дэмжих нь чухал ач холбогдолтой. Гэтэл залуучуудын оролцоог дэмжих, нийгмийн шийдвэр гаргах үйл явцад оролцох гол нөхцөл болох залуучуудын эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих талаар тусгаагүй байна.

¹ Төрийн албаны тухай хуулийн 53.1 зүйл, Засгийн газрын 2020 оны 12 дугаар 16-ны өдрийн 216 тоот тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123502818151>

² НҮБ-ын Залуучуудын стратеги 2030, <https://www.un.org/youthenvoy/youth-un/>

Эрхэм зорилго: Стратегийн төсөлд эрхэм зорилгыг огт тодорхойлоогүй байна. Тиймээс хуулиар хүлээсэн чиг үүрэгт үндэслэсэн, залуучуудын хөгжлийн эрхэм тодорхойлохдоо залуучуудын нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэл, үнэт зүйлийг хөгжлийн гол үзэл баримтлал болгон тусгаж тодорхойлох шаардлагатай.

Орчны шинжилгээ: Стратегийн төсөлд дотоод орчны шинжилгээ, гадаад хүчин зүйлсийг дүгнэж, үнэлээгүй байна. Төсөлд залуучуудад тулгарч буй асуудлуудыг дурдаж, судалгаа, олон улсын сайн туршлагуудыг эш татсан боловч тус судалгаануудын бодитой дүн шинжилгээ, боловсруулалт хангалтгүй, асуудлын суурь шалтгаан тодорхой бус байна. Асуудалтай тэмцэх бус асуудлын суурь шалтгааныг арилгах чиглэлээр цогц арга хэмжээг оновчтой төлөвлөх шаардлагатай.

Найруулгын санал: Стратегийн төслийн найруулгын болон үг, үсгийн алдааг засаж сайжруулах шаардлагатай байна.

2. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох

Шалгуур үзүүлэлт болон **зорилтот түвшний үнэлгээг** стратегийн зорилт бүрээр тусгайлан тодорхойлоогүй тул одоогийн нөхцөл ба ирээдүйд хүлээж буй үр дүнг харьцуулан шинжлэх боломжгүй байна. Тухайлбал: Арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.2, 1.1.4, 1.1.8 зэрэг арга хэмжээний хүлээж буй үр дүнг “... дахин” нэмэгдүүлэх гэж тодорхойлох нь стратегийн хэрэгжилтийг үнэлэх, үр дүнг хэмжихэд ойлголтын зөрүү бий болгох, улмаар үр нөлөөг бодитоор хэмжиж үнэлэхгүй байх эрсдэл бий болгоно.

3. Стратегийн хяналтын механизмыг бий болгох

Стратегийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг үнэлэх, явцын үнэлгээ, мониторинг хийх талаар стратегид огт дурдаагүй байна. Аливаа стратеги төлөвлөлтөд хяналт тавих үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх нь зорилтот бүлгийн оролцоог нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийг сайжруулахад чухал ач холбогдолтой байдаг. Стратегийн биелэлтэд хяналт тавих олон улсын сайн туршлагуудыг авч хэрэгжүүлбэл зохилтой. Жишээ нь: Цахим хяналтын платформ хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах талаар тусгах.

Олон улсын туршлагаас дурдвал Норвег улсын Үндэсний хүүхэд, залуучуудын зөвлөл³ нь залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянаж, жил бүр тайлан үнэлгээ гаргаж, олон нийтэд нээлттэй танилцуулдаг. Бүх процесст иргэний нийгмийн бодитой, утга учиртай оролцоог сайн хангадаг. Зөвлөлөөс гарсан тайлан, зөвлөмж нь Засгийн газрын шийдвэр гаргах, үйл ажиллагаанд тусдаг байна.

³ <https://www.lnu.no/english/>

Финланд улс залуучуудын дуу хоолойг бодлогын хэрэгжилтэд тусгах, ил тод байдлыг хангах, хяналт тавих боломжийг олгох зорилготой "Otakantaa.fi" (Let's Participate)⁴ цахим платформыг нэвтрүүлсэн. Энэхүү платформуор дамжуулж залуучууд санал, зөвлөмжийг авах, гомдол гаргах, бодлого боловсруулахад оролцоог нь хангадаг.

Мөн Швед улсын "Swedish Agency for Youth and Civil Society"⁵ агентлаг, Нидерланд улсын "Youth Policy Review"⁶ зэрэг механизмууд нь залуучуудын хөгжлийг дэмжих бодлогынхоо нэн тэргүүнд иргэний нийгмийн хяналт, оролцоо, хамтын ажиллагааг хангадаг байна.

4. Олон Улсын баримт бичгүүдтэй уялдуулан сайжруулах

Монгол Улсын үүрэг хүлээсэн олон улсын баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж байгаа талаар тодорхой бус байна. Тиймээс НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027⁷, НҮБ-ын "Ирээдүйн төлөө гэрээ" болон түүний хавсралт болох "Ирээдүй хойч үеийн асуудлаарх тунхаглал"⁸ зэрэг олон улсын баримт бичиг, бодлогуудтай Үндэсний стратегиа уялдуулах шаардлагатай байна.

5. Нэн тэргүүний ач холбогдол өгч шийдвэрлэх шаардлагатай орхигдсон асуудлууд

Залуучуудын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хамгаалах талаар тодорхой заалт дутагдалтай байна. Эдгээр эрхийг хангах нь залуучуудын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд оролцох үндэс суурь болдог. Тиймээс залуучуудын, тэр дундаа хүн бүрийн үндсэн эрх чөлөөг хүндэтгэх, залуучуудын иргэний орон зай, залуучуудын үндсэн эрх чөлөөнд онцгой анхаарал хандуулах нь сайн засаглалын чухал урьдчилсан нөхцөл юм. Иймд:

- Үндэсний, орон нутгийн түвшинд залуучуудад зориулсан иргэний орон зайн судалгаа, мониторинг хийх, иргэний орон зай дахь залуучуудын оролцоог үнэлэх;
- Иргэний нийгмийн залуучууд, хүний эрх хамгаалагч залуучуудыг дэмжих замаар нийгэмд үйлчилдэг иргэний нийгмийн салбарт залуучууд ажиллах боломж бүрдүүлэх,

⁴ <https://www.otakantaa.fi/fi/>

⁵ <https://www.mucf.se/en>

⁶ <https://www.youthpolicyreview.com/>

⁷ [Линк](#)

⁸ [Ирээдүй хойч үеийн асуудлаарх тунхаглал](#)

- Залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын өөрчлөлтийн нөлөө, нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөллийг үнэлж, орон нутгаас эхлээд үндэсний түвшинд шийдвэр гаргахад хараат бус, бие даасан залуучуудын байгууллагуудыг татан оролцуулах замаар залуучуудын бодит оролцоог нь дэмжих;

Залуучуудад ээлтэй татварын болон нийгмийн даатгалын бодлого, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг арилгах талаар цогц арга хэмжээ, залуучуудын олон талт байдалд нийцсэн, тохирсон бодлого, Технологиос үүдэлтэй залуучуудын (цахим хүчирхийллээс ангид байх, хувийн мэдээллээ хамгаалуулах, хувийн нууцтай байх, халдашгүй дархан байх ... зэрэг) эрхийн зөрчлийг арилгах чиглэлээрх асуудлуудыг анхааралдаа авч, стратегидээ тусгах.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын "Залуучуудын хөгжлийн стратеги (2025-2030)" төсөл нь хэлбэр, агуулга, бүтцийн шаардлагуудыг хангаагүйгээс гадна зорилтууд нь хэт ерөнхий бөгөөд хэмжигдэхүйц бус, хүлээж буй үр дүнд үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна. Түүнчлэн стратегийн хэрэгжилтийг хангахад залуучуудын оролцоог баталгаажуулах, хяналт тавих механизмыг бий болгох, олон талт хамтын ажиллагааг хангах зайлшгүй шаардлагатай байна.

Цаашид энэ стратегийг сайжруулах, хүүхэд залуучуудтай холбоотой хүний эрхийн тулгамдаж буй асуудлыг зөв эрэмбэлж, зохистой хэрэгжүүлэхийн тулд залуучуудын оролцоог нийгэм, улс төрийн бүх түвшинд нэмэгдүүлэх, олон улсын сайн туршлагуудыг ашиглах, судалгаа, шинжилгээг сайжруулах шаардлагатай. Энэ нь зөвхөн стратегийн төслийг чанартай боловсруулахад бус хэрэгжилтийн үе шатанд үр дүнтэй мониторинг, үнэлгээ хийх боломжийг бий болгож, залуучуудын оролцоог дэмжихэд чухал алхам болно.

Энэхүү стратегийн төслийг сайжруулах, илүү тодорхой, хэмжигдэхүйц, үндсэн эрх чөлөөнд тулгуурласан байдлаар боловсруулах нь Монгол Улсын залуучуудын хөгжлийг дэмжих ажлыг эрчимжүүлэх, улс орныхоо ирээдүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломжийг олгоно.

--oOo--